



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/81

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Хэрлэн суманд коронавирусын цар тахлын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан коронавирусын цар тахлын голомтод ажилласан Нэгдсэн эмнэлгийн 13 ажилтныг 2021 оны 4 дүгээр сарын 16-наас 5 дугаар сарын 14-н хүртэлх өдрүүдэд нийт 3 удаа, Улаанбаатар хотоос хүнс тээвэрлэсэн 63 жолоочийг 4 дүгээр сарын 29-нөөс 5 дугаар сарын 21 хүртэлх өдрүүдэд тусгаарлах байранд байрлуулсан зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 13,760,000 (Арван гурван сая долоон зуун жаран мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансны хандивын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| № | Зардлын нэр | Он сар өдөр | Хүн ий тоо | Хоногийн тоо | Нэгжийн үнэ | Нийт дүн |
|-------------------|-----------------|------------------|---------------|-----------------|----------------|-------------------|
| Нямодо трейд ХХК | | | | | | |
| 1 | Буудлын үнэ | 2021.04.16-05.14 | 13 | 21 | 10,989 | 3,000,000 |
| 2 | Хоолны үнэ | 2021.04.16-05.14 | 13 | 21 | 10,109 | 2,760,000 |
| | Дүн | | 13 | 21 | 21,098 | 5,760,000 |
| Хөвчийн жонон ХХК | | | | | | |
| 1 | Буудлын үнэ | 2021.05.01-05.21 | 20 | 21 | 7,143 | 3,000,000 |
| | Дүн | | 20 | 21 | 7,143 | 3,000,000 |
| Эрдэнэпойнт ХХК | | | | | | |
| 1 | Буудлын үнэ | 2021.04.29-05.21 | 43 | 21 | 5,537 | 5,000,000 |
| | Дүн | | 43 | 21 | 5,537 | 5,000,000 |
| | Нийт дүн | | | | | 13,760,000 |